

Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтад Сангийн сайд Н.Баяртсайханы тавих илтгэл

Эрхэмсэг ноёд, хатагтай нараа,

Хүндэт зочид төлөөлөгчид Та бүхний амар амгаланг айлтгая!

Монгол улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд тогтвортой өсөж байна. Эдийн засгийн бодит өсөлт урьдчилсан байдлаар 2006 онд 8.0 орчим хувьтай гарах төлөвтэй байна.

Дэлхийн зах зээлд алт, зэсийн үнэ өссөн, нэхмэл бүтээгдэхүүний экспорт, уул, уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдсэн зэргээс Монгол улсын экспортын орлого 2006 онд 1.5 тэрбум ам.долларт хүрэх төлөв харагдаж байна. Үүний дүнд манай улсын 2006 оны гадаад худалдааны тэнцэл улмаар улсын төсөв ашигтай гарах боломж бүрдэж буйг тэмдэглэхэд таатай байна.

Засгийн газраас төсөв, санхүүгийн тогтвортой бодлого явуулсны дүнд инфляци буурч 2006 оны эхний хагас жилийн байдлаар 5.7 хувьтай байна.

Банкны чанаргүй зээлийн эзлэх хэмжээ жил тутам тогтвортой буурч 2005 оны эцсийн байдлаар 6.3 % болж буурлаа.

Манай улсын банк, санхүүгийн зах зээлийн үйлчилгээнд нааштай ахиц дэвшлүүд гарч байна.

Өнөөдөр манай улсын санхүүгийн зах зээлд 16 банк, 19 даатгалын компани, 27 үнэт цаасны байгууллага, 150 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Засгийн газраас банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх, тогтворжилтыг бататгах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар банкны эрүүл тогтолцоог бүрдүүлэх, төрийн өмчийн оролцоотой арилжааны банкуудыг дотоод, гадаадын нэр хүнд бүхий стратегийн хөрөнгө оруулагчдад хувьчлах, төрийн өмчийн оролцоог багасгаснаар банкны тогтолцоог үндсэнд нь хувийн хэвшилд шилжүүлснээр банк, санхүүгийн салбарын үйл ажиллагаа тогтворжин хөгжиж байна.

Банкны үйл ажиллагаа тогтворжиж, идэвхижихийн хирээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын банкинд итгэх итгэл дээшилж, эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлж байна.

Төрөөс авч хэрэгжүүлж буй эдийн засгийн бодлого, бодит салбарын хөгжлийн үйл явцтай уялдан даатгалын үйлчилгээний хамрах цар хүрээ тэлж, үзүүлж буй үйлчилгээний нэр төрөл олширч байна. Эдүгээ даатгалын 19 компани арилжааны даатгалын үйл ажиллагааг явуулж байгаа бөгөөд 2005 оны байдлаар 9 тэрбум хураамжийн орлого цуглуулсан байна.

Энэ секторын хувьд тэтгэврийн болон урт хугацааны амьдралын даатгалын бүтээгдэхүүний орон зай байгаа бөгөөд эдгээрийн эрэлт хэрэгцээ эрс нэмэгдэх төлөвтэй байна.

Монгол улсын үнэт цаасны зах зээл 1991 онд үүссэн бөгөөд одоогын байдлаар нийт 27 үнэт цаасны мэргэжлийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. 2001 оноос эхлэн бондын арилжаа идэвхижиж эхэлсэн. 2005 оны байдлаар Хөрөнгийн биржид 392 компани

бүртгэлтэй байгаа бөгөөд эдгээр компаниудын зах зээлийн үнэлгээ 55 тэрбум 701 сая төгрөгт хүрсэн байна.

Хөрөнгө оруулалтын санхүүгийн таатай орчныг бүрдүүлэх, түүний дэд бүтцийг бэхжүүлэх, бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох, санхүүгийн ил тод байдлыг хангах, чөлөөт өрсөлдөөнийг нэмэгдүүлэх чиглэлд Монголын төрөөс ихээхэн анхаарч ажиллаж байна. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, Авлигатай тэмцэх тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай зэрэг хуулиудыг батлан гаргалаа.

Эдгээр хуулиуд батлагдсанаар банк, санхүүгийн тогтолцооны эрүүл, тогтвортой байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх талаар олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ Монгол улс биелүүлэхэд чухал алхам болло.

Олон улсын зах зээлд Монгол улсын зээлжих зэрэглэлийн түвшин жил бүр ахиж байна. Манай улсын богино хугацааны зээлжих зэрэглэлийг В, урт хугацааны зээлжих зэрэглэлийг В+ болгож 2005 онд шинэчлэн тогтоосон бөгөөд ерөнхий төлвийг тогтвортой гэж үнэлсэн болно. Зээлжих зэрэглэл ингэж ахиснаар гадаадын улс орнуудаас Монгол улсад оруулах ирэх шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд итгэл төрүүлэх төдийгүй, Засгийн газар болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд олон улсын санхүүгийн зах зээлээс зээлжих боломж бүрдэх, олон улсын үнэт цаасны зах зээлд манай компаниуд хувьцаа, үнэт цаасаа арилжаалах үүд хаалга нээгдэж байна гэж үзэж болох юм.

Монгол улсын Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, түүнийг татах чиглэлээр олон арга хэмжээ авч явуулсны дүнд сүүлийн жилүүдэд гадаадын хөрөнгө оруулалт тогтвортой нэмэгдэж байна. Сүүлийн арван жилийн хугацаанд манай улсын ДНБ-тэй тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэв. Гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 2005 оны байдлаар 317 сая ам.долларт хүрсэн нь 2004 оны мөн үетэй харьцуулахад 34 хувиар өсчээ. Гадаадын хөрөнгө оруулалт бүтцийн хувьд геологи, уул уурхай, худалдаа, хөнгөн үйлдвэрлэлийн салбарт зонхилж байна.

Татварын шинэчлэлийн томоохон арга хэмжээ авлаа. **Үүнд:**

(1) Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуулиар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хэмжээг 10 ба 25 болгосны хамт 25 хувийн татвар ногдуулах орлогын босгыг 3 тэрбум төгрөг байхаар өндөрсгөж тогтоов. Түүнчлэн татвар төлөгчдийн үйл ажиллагааны бизнесийн зардлыг татвар ногдох орлогоос хасагдах зардалд бүрэн тусгахаар болгож, аж ахуй эрхлэгч нарт үзүүлэх эрхзүйн тааламжтай шинэ орчин, нөхцөл бүрдэх боломж гарлаа.

(2) Хүн амын орлогын албан татварын тухай хуулиар хүн амын орлогын албан татварын одоо үйлчилж буй 3 шатлал буюу 10, 20, 30 хувийг өөрчилж, хүн амын орлогын албан татвар төлөгчийн жилд буюу сард олсон цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дүнгийн 10 хувиар бодож татвар ногдуулах болгох арга хэмжээ авлаа. **Өөрөөр хэлбэл**, хүн амын орлогын хэмжээнээс хамааруулан ялгавартай хувь хэмжээгээр татвар ногдуулж ирсэн журмыг 2007 оноос халж, татварын нэг шатлалын тогтолцоонд шилжүүлэх зоримог алхам хийлээ.

(3) Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиар нэмэгдсэн өртгийн албан татварын хувь хэмжээ 15 байсныг 10 хувь хүртэл бууруулах шийдвэрийг гаргалаа. Энэхүү

шийдвэр нь бизнес эрхлэгч нарт аж ахуй эрхлэх татварын боломжтой нөхцөлийг бүрдүүлсэн төдийгүй нийт хүн амын амьдралын өртгийг бууруулахад нөлөөлөхүйц чухал арга хэмжээ болсон гэж үзэж байна. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг УИХ-аар шинэчлэн баталсантай холбогдуулан татварын аливаа хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасгах зарчим баримталж байна.

Татварын шинэ хуулийг мөрдүүлснээр манай улс татварын орчны хувьд олон улсын хэмжээнд харьцангуй бага татвартай орны тоонд багтаж, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг дэмжих, тааламжтай нөхцөлийг зохих ёсоор бүрдүүллээ гэж үзэж байна. .

Хөрөнгө оруулагчдад чирэгдэл учруулдаг бэрхшээлийг халах зорилгоор Авилгалын эсрэг хуулийг баталж, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд олгогддог 600 гаруй төрлийн тусгай зөвшөөрлийг 87 болтол цөөлсөн явдал ихээхэн ач холбогдолтой болсон юм.

Монгол улсад оруулах гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулагчид болон өөрийн улсын ашиг сонирхлын аль алиныг хангах тэнцвэртэй бодлогыг тууштай баримталж ажиллах болно.

Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж буй “Монгол улс: Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт-2006”-д хүрэлцэн ирсэн Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид Та бүхэнд чуулганы үйл ажиллагаанд амжилттай оролцохыг хүсэн ерөөе!

Бидний хамтын ажиллагаа улам өргөжинө гэдэгт итгэж байна.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Улаанбаатар хот

2006 оны 9 дүгээр сар 14